

## **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ**

Огноо: **2018 оны 11-р сарын 13**

1. “Монголросцветмет” ХХК-ийн харьяа “Бор-Өндөр”-ийн УБҮ нь “Баргилт”-ын төмрийн ордод гүйцэтгэх геофизикийн гүний тандан судалгаа, ЗХ IP албадмал туйлшралын аргаар цахилгаан хайгуул, хүндийн хүч, гравиметрийн судалгааны ажлыг хийлгэхээр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Бор-Өндөр”-ийн УБҮ-ээс БХ зүгт 18.0 км-т байрлах “Баргилт”-ын төмрийн ордын хүдрийн биетийн агуулга, байрлалын элемент, талбайн тархалт, гүндээ хир үргэлжлэх, тасрал эвдрэл, хагарлын чиглэл, ашигт эрдсийн хил зааг зэргийг зураглах, геофизикийн иж бүрэн мэдээллийг авч, программ хангамжаар боловсруулах, үр дүнгийн тайланг зохиож, хүлээлгэн өгч, зөвлөх цогц судалгааны ажил болно. Уурхайн олборлолтын цаашдын үйл ажиллагааг жигд, найдвартай хангаж ажиллах зорилгоор тухайн ажлыг 1.5 сар хүртлэх хугацаанд хэрэгжүүлнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (санхүүгийн бичиг баримт, ШШГЕГ, НДГ, Татвар болон банкны тодорхойлолт, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, ААН-ийн гэрчилгээ зэрэг нийтлэг ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт), ТБОНӨХБАҮХАТХуулийн -14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ.

4. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 17 цаг** хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ доорх **2018 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 10:00** цагаас өмнө ирүүлнэ үү.

**Хаяг: “Монголросцветмет” ХХК “Бор-Өндөр” УБҮ,  
Бор-Өндөр сум, УБҮ-ийн төв байр 3 давхар, Хэнтий аймаг,  
Утас: 70567507-/1057/, 91996488, 80898188,  
Холбоо барих ажилтан: УБҮ-ийн ГМА-ны ерөнхий геологич Д.Батболд  
boldoo\_geo@yahoo.com**